

ЭЛЧИН САЙД ЛЕКЦ УНШИВ

ОХУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Самойленко Виктор Васильевич 2010 оны 5 дугаар сарын 26- өдөр ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн урилгаар “ОХУ ба Монгол Улсын орчин үеийн харилцаа ба тулгамдсан асуудлууд” сэдвээр нээлттэй лекц уншив. Уг лекцэнд ШУА-ийн Ерөнхийлөгч, академич Б.Энхтүвшин, ШУА-ийн Нийгмийн ухааны бага чуулганы эрдэмтэн нарийн бичгийн дарга О.Адьяа, Олон улс судлалын хүрээлэнгийн захирал, профессор Л.Хайсандай болон ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, ФСЭЗ хүрээлэн, Монгол Оросын найрамдлын нийгэмлэг, Алтанбулгийн чөлөөт бүс зэрэг Орос улстай харилцаа бүхий байгууллагын ажилтан, хүмүүс оролцож, Элчин сайд лугаа дэлгэрэнгүй санал солилцов.

Орос, Монголын харилцааны асуудлаар илэн далангүй ярилцсан энэхүү лекц, ярилцлага хоёр улсын хоорондын асуудлуудад бодитой хандах шаардлагатайг илэрхийлсэн чухал үйл явдал болов.